



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn  
Ахлах аудитор: П.Амарсанаа  
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихэрмөрөн-Аудит" ХХК  
Захирал Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2.3 Албан шаардлага.....	18
4.2.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/434  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ  
Б. ИЧИНХОРЛОО ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>130,414,102.16</b>	<b>148,915,377.11</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>35,100.00</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>35,100.00</b>
31110	Төгрөг	-	35,100.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,924,619.16</b>	<b>33,936,981.11</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	43,362.00	4,737,329.95
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	120,000.00	120,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,257,262.74	16,117,536.74
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>503,994.42</b>	<b>12,962,114.42</b>
3351	Байгууллагаас авах авлага	1,004.00	12,459,124.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	502,990.42	502,990.42
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>20,973,144.00</b>	<b>2,724,744.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	20,973,144.00	2,724,744.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>106,516,339.00</b>	<b>112,218,552.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,200,000.00</b>	<b>1,168,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	1,200,000.00	1,168,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	54,403,488.00	54,637,071.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>50,912,851.00</b>	<b>56,413,481.00</b>
35410	Бичиг хэргийн материал	22,861,525.00	18,948,880.00
35420	Аж ахуйн материал	4,007,494.00	6,896,249.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,001,000.00	914,180.00
35440	Түлш, шатах тослох материал	890,000.00	1,050,000.00
35450	Барилгын засварын материал	921,800.00	159,500.00
35470	Бусад хангамжийн материал	21,231,032.00	28,444,672.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,954,712,156.99</b>	<b>6,033,597,085.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,954,712,156.99</b>	<b>6,033,597,085.37</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,672,670,990.21</b>	<b>5,749,938,060.11</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,316,283,636.00	1,316,283,636.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(265,586,156.72)	(397,420,785.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,300,000.00	25,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,300,000.00)	(25,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	920,351,638.68	740,207,254.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(763,187,645.17)	(466,884,301.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	244,430,642.47	216,491,481.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(176,987,189.87)	(156,171,812.89)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	2,974,884,400.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,972,175.60	61,957,662.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(60,277,784.58)	(39,266,219.37)
39217	Ном	4,376,671,673.80	1,499,856,743.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>282,041,166.78</b>	<b>283,659,025.26</b>
39301	Програм хангамж	28,950,000.00	29,527,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,505,833.22)	(20,711,874.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	304,047,800.00	312,847,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(34,450,800.00)	(38,004,400.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,085,126,259.15</b>	<b>6,182,512,462.48</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>8,875,321.95</b>	<b>535,237.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,505,488.50</b>	<b>535,237.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>4,505,488.50</b>	<b>535,237.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,102,841.50	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,977.00	2,977.00

<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,399,670.00	532,260.00
41361	Байгууллагад төлөх өглөг	220,690.00	89,840.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,178,980.00	442,420.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,369,833.45	-
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	4,369,833.45	-
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	4,369,833.45	-
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,369,833.45	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,076,250,937.20</b>	<b>6,181,977,225.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>6,076,250,937.20</b>	<b>6,181,977,225.48</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,834,267,039.88	1,834,267,039.88
51101	Өмч: - төрийн	1,834,267,039.88	1,834,267,039.88
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>132,969,782.85</b>	<b>240,069,978.01</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	277,423,519.89	135,510,097.21
51220	Тайлант үеийн үр дүн	(144,453,737.04)	104,559,880.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,109,014,114.47	4,107,640,207.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,085,126,259.15</b>	<b>6,182,512,462.48</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,241,443,398.00</b>	<b>2,923,274,054.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,705,580.00</b>	<b>133,438,670.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	49,690,580.00	133,438,670.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,690,580.00	133,438,670.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,690,580.00	133,438,670.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	15,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	15,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,191,737,818.00</b>	<b>2,789,835,384.60</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,938,145,300.00	2,051,411,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,938,145,300.00	2,051,411,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	253,592,518.00	738,424,284.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	230,250,063.00	238,839,784.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	467,316,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,342,455.00	32,268,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,383,506,617.15</b>	<b>2,822,012,173.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,383,506,617.15</b>	<b>2,822,012,173.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,846,578,668.02</b>	<b>2,240,101,360.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,274,748,044.00</b>	<b>1,379,883,041.24</b>
210101	Үндсэн цалин	803,637,967.00	1,045,297,177.24
210102	Нэмэгдэл	246,968,572.00	227,430,564.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,718,508.00	107,155,300.00
210104	Урамшуулал	140,264,427.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	26,158,570.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>159,317,736.37</b>	<b>179,653,671.21</b>
210201	Тэтгэврийн даатгал	109,572,057.45	125,577,634.95
210202	Тэтгэмжийн даатгал	12,882,012.30	14,006,847.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,218,323.23	11,152,807.31
210204	Ажилгүйдлийн даатгал	2,419,831.51	2,610,581.69
210205	Эрүүл мэндийн даатгал	24,225,511.88	26,305,800.21

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>54,851,885.85</b>	<b>57,178,022.06</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,556,024.00	12,638,987.00
210302	Түлш, халаалт	26,470,594.95	40,207,789.00
210303	Цэвэр, бохир ус	3,825,266.90	4,331,246.06
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>57,963,251.68</b>	<b>131,443,601.54</b>
210401	Бичиг хэрэг	10,090,057.00	19,582,030.00
210402	Тээвэр, шатахуун	2,122,000.00	1,740,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,700,645.68	18,049,046.79
210404	Ном, хэвлэл	16,275,374.00	39,819,302.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	6,582,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,869,075.00	45,670,922.00
210408	Бараа материал акалсны зардал	2,906,100.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>898,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	898,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,149,560.00</b>	<b>30,316,220.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	219,860.00	-
210604	Урсгал засвар	2,929,700.00	30,316,220.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,074,664.00</b>	<b>234,168,290.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,100,684.00	160,460,052.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,048,000.00	7,298,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,650.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,921,660.00	65,699,103.00
210807	Газрын төлбөр	639,870.00	631,135.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	23,800.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>237,473,526.12</b>	<b>226,560,514.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,409,495.00	4,913,272.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	1,346,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	234,714,031.12	220,301,241.62
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>96,275.60</b>	<b>586,414.40</b>
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>96,275.60</b>	<b>586,414.40</b>
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	96,275.60	586,414.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>536,831,673.53</b>	<b>581,324,399.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>103,949,286.00</b>	<b>119,793,442.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,749,434.00	109,523,442.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,199,852.00	10,270,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>432,882,387.53</b>	<b>461,530,957.23</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	432,289,177.53	355,948,734.98
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	593,210.00	105,582,222.25
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(142,063,219.15)</b>	<b>101,261,880.80</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,999,999.63</b>	<b>5,093,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,999,999.63	5,093,000.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,390,517.52</b>	<b>1,795,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,333.52	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,379,184.00	1,795,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(2,390,517.89)</b>	<b>3,298,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(144,453,737.04)</b>	<b>104,559,880.80</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,834,267,039.88</b>	<b>4,109,225,340.09</b>	<b>273,212,294.26</b>	<b>6,216,704,674.23</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	211,225.63	211,225.63
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,834,267,039.88</b>	<b>4,109,225,340.09</b>	<b>273,423,519.89</b>	<b>6,216,915,899.86</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(211,225.63)	-	(211,225.63)
Тайлант үеийн үр дүн	-	-	(144,453,737.04)	(144,453,737.04)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,834,267,039.88</b>	<b>4,109,014,114.47</b>	<b>132,969,782.85</b>	<b>6,076,250,937.20</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,540,314.36	2,540,314.36
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,834,267,039.88</b>	<b>4,109,014,114.47</b>	<b>135,510,097.21</b>	<b>6,078,791,251.56</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,373,906.88)	-	(1,373,906.88)
Тайлант үеийн үр дүн	-	-	104,559,880.80	104,559,880.80
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,834,267,039.88</b>	<b>4,107,640,207.59</b>	<b>240,069,978.01</b>	<b>6,181,977,225.48</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,199,092,827.89</b>	<b>2,797,256,897.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>71,250.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	71,250.00
120009	Бусад орлого	-	71,250.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,199,092,827.89</b>	<b>2,797,185,647.34</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,938,145,300.00	2,051,411,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,938,145,300.00	2,051,411,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>260,947,527.89</b>	<b>745,774,547.34</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	233,594,317.89	241,097,047.34



131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	467,316,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,353,210.00	37,361,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,154,051,407.89</b>	<b>2,633,912,197.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,154,051,407.89</b>	<b>2,633,912,197.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,615,007,471.62</b>	<b>2,036,470,261.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,274,918,990.04</b>	<b>1,378,784,389.75</b>
210101	Үндсэн цалин	995,813,089.04	1,054,341,158.35
210102	Нэмэгдэл	260,138,325.00	221,302,486.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,967,576.00	103,140,745.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>159,494,454.25</b>	<b>179,803,849.67</b>
210201	Тэтгэврийн даатгал	126,164,389.14	134,584,342.65
210202	Тэтгэмжийн даатгал	10,930,630.02	11,774,505.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,650,423.42	9,396,083.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,034,535.65	2,186,273.96
210205	Эрүүл мэндийн даатгал	11,714,476.02	21,862,643.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,328,161.15</b>	<b>62,134,269.91</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,556,024.00	12,638,987.00
210302	Түлш, халаалт	26,946,870.25	45,164,036.85
210303	Цэвэр, бохир ус	3,825,266.90	4,331,246.06
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,282,994.18</b>	<b>89,357,300.54</b>
210401	Бичиг хэрэг	7,577,230.00	8,299,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,572,000.00	1,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,565,645.68	18,969,046.79
210404	Ном, хэвлэл	9,894,608.50	35,499,413.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	8,842,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,673,510.00	15,847,340.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>6,800,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	6,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,844,420.00</b>	<b>27,621,640.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,308,890.00	523,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,639,030.00	1,607,200.00
210604	Урсгал засвар	1,896,500.00	25,490,840.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>58,829,075.00</b>	<b>270,477,302.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,855,095.00	191,729,064.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,048,000.00	7,298,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,650.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,921,660.00	65,239,103.00
210807	Газрын төлбөр	639,870.00	631,135.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	23,800.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,309,377.00</b>	<b>21,491,509.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,025,177.00	19,234,909.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,284,200.00	2,256,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>539,043,936.27</b>	<b>597,441,935.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>103,904,286.00</b>	<b>119,793,442.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,749,434.00	109,523,442.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,154,852.00	10,270,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	435,139,650.27	477,648,493.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	432,289,177.53	356,019,984.98
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,850,472.74	121,628,508.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>45,041,420.00</b>	<b>163,344,700.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>45,042,220.00</b>	<b>163,309,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>45,042,220.00</b>	<b>163,309,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	45,042,220.00	163,309,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,042,220.00	163,309,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(45,042,220.00)</b>	<b>(163,309,600.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(800.00)	35,100.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	800.00	
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		35,100.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,051,411,100.00</b>	<b>1,695,462,365.02</b>	<b>355,948,734.98</b>	<b>82.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,051,411,100.00</b>	<b>1,695,462,365.02</b>	<b>355,948,734.98</b>	<b>82.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,927,211,000.00</b>	<b>1,585,688,923.02</b>	<b>341,522,076.98</b>	<b>82.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,435,112,100.00</b>	<b>1,163,939,123.15</b>	<b>271,172,976.85</b>	<b>81.1</b>
210101	Үндсэн цалин	970,985,100.00	839,495,891.75	131,489,208.25	86.5
210102	Нэмэгдэл	402,135,000.00	221,302,486.40	180,832,513.60	55.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,992,000.00	103,140,745.00	(41,148,745.00)	166.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>193,740,000.00</b>	<b>150,606,968.16</b>	<b>43,133,031.84</b>	<b>77.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	136,335,600.00	105,387,461.14	30,948,138.86	77.3
210202	Тэтгэмжийн даатгал	14,351,100.00	11,774,505.86	2,576,594.14	82.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,480,900.00	9,396,083.80	2,084,816.20	81.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,870,200.00	2,186,273.96	683,926.04	76.2
210205	Эрүүл мэндийн даатгал	28,702,200.00	21,862,643.40	6,839,556.60	76.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,080,200.00</b>	<b>62,134,269.91</b>	<b>23,945,930.09</b>	<b>72.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	38,412,000.00	12,638,987.00	25,773,013.00	32.9

АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	40,909,500.00	45,164,036.85	(4,254,536.85)	110.4
210303	Цэвэр, бохир ус	6,758,700.00	4,331,246.06	2,427,453.94	64.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>112,821,500.00</b>	<b>110,959,023.30</b>	<b>1,862,476.70</b>	<b>98.4</b>
210401	Бичиг хэрэг	3,113,700.00	3,113,400.00	300.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,900,900.00	1,900,000.00	900.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,081,800.00	14,079,593.30	2,206.70	100.0
210404	Ном, хэвлэл	65,712,500.00	65,712,430.00	70.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,700,000.00	8,842,300.00	1,857,700.00	82.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,312,600.00	17,311,300.00	1,300.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,800,000.00</b>	<b>6,800,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,800,000.00	6,800,000.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,607,200.00</b>	<b>20,598,040.00</b>	<b>9,160.00</b>	<b>100.0</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,607,200.00	1,607,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	19,000,000.00	18,990,840.00	9,160.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>50,524,200.00</b>	<b>49,159,989.00</b>	<b>1,364,211.00</b>	<b>97.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,088,300.00	15,763,074.00	325,226.00	98.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,348,000.00	7,298,000.00	50,000.00	99.3
210803	Даатгалын үйлчилгээ	360,000.00	-	360,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	80,000.00	320,000.00	20.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,893,100.00	19,887,780.00	5,320.00	100.0
210807	Газрын төлбөр	640,000.00	631,135.00	8,865.00	98.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	294,800.00	-	294,800.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэл, бэлтгэх	5,500,000.00	5,500,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,525,800.00</b>	<b>21,491,509.50</b>	<b>34,290.50</b>	<b>99.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,247,100.00	19,234,909.50	12,190.50	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,278,700.00	2,256,600.00	22,100.00	99.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>124,200,100.00</b>	<b>109,773,442.00</b>	<b>14,426,658.00</b>	<b>88.4</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>805,000.00</b>	<b>-</b>	<b>805,000.00</b>	<b>-</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	805,000.00	-	805,000.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>123,395,100.00</b>	<b>109,773,442.00</b>	<b>13,621,658.00</b>	<b>89.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,067,100.00	109,523,442.00	13,543,658.00	89.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	250,000.00	78,000.00	76.2
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,051,411,100.00</b>	<b>1,695,462,365.02</b>	<b>355,948,734.98</b>	<b>82.7</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,051,411,100.00</b>	<b>1,695,462,365.02</b>	<b>355,948,734.98</b>	<b>82.7</b>

131001	Улсын төсвөөс санхүүжих	2,051,411,100.00	1,695,462,365.02	355,948,734.98	82.7
	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>112</b>	<b>96</b>	<b>(16)</b>	<b>85.7</b>
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	81	71	(10)	87.7
	Үйлчлэх ажилтан	30	24	(6)	80.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>745,739,447.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>745,739,447.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	614,090,938.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	214,845,266.60
210101	Үндсэн цалин	-	214,845,266.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	29,196,881.51
210201	Тэтгэврийн даатгал	-	29,196,881.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	40,600,477.24
210401	Бичиг хэрэг	-	5,185,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	4,889,453.49
210404	Ном, хэвлэл	-	29,912,183.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	613,040.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	101,631,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	95,131,000.00
210604	Урсгал засвар	-	6,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	227,817,313.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	182,465,990.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	45,351,323.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	10,020,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	10,020,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,020,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>121,628,508.99</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>745,774,547.34</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>745,774,547.34</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	241,097,047.34
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	467,316,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	37,361,400.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	35,100.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа, ахлах аудитор Д.Оюундаваа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Б.Мядагмаа хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Үндэсний номын сан 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монголын Улсын Үндэсний номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг Номын сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “ Монгол Улсын Үндэсний номын сан нь монголын ард түмний бичиг үсгийн дурсгалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үүрэг бүхий байгууллага байна” гэж заасан байна.

Тус номын сан нь Монголын ард түмний бичиг үсгийн дурсгал болох соёлын баримтат өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, ном хэвлэлийг сурталчлах, үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг зохион байгуулах, бусад номын санг эрдэм шинжилгээ-судалгаа, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлахаас гадна ном уншлагын цахим болон танхимын үйлчилгээ үзүүлдэг Соёлын яамны харьяа байгууллага юм.

Тус номын сан тайлант онд Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 250 дугаар тогтоол, Соёлын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/50 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хүрээнд Монгол улсад орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойг орон даяар зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлсний дотор цахим номын сангийн тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах, цахим мэдээлийн сан үүсгэх зэрэг төлөвлөсөн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Номын сангийн шинэ барилга руу нүүх ажлын бэлтгэл ажлын хүрээнд ашиглалтын өмнөх түр албыг байгуулж, нүүлгэн шилжүүлэх болон нүүхийн өмнөх бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу сан хөмрөгт номын тооллого хийх, данс бүртгэлд тэмдэглэгээ хийх, номыг шинжлэх ухааны ангиллаар цэгцлэн байрлуулах, баркоджуулах ажлууд хийгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль /нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ/;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага 2021 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын газраас улирал бүр шилэн дансны хяналтыг хэрэгжүүлж, 1 зөвлөмж өгснийг биелүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлсэнээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,383,506.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 35,752.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97,386.2 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар нэмэгджээ.

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансанд тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	35.1	35.1
Авлага	2,924.6	33,936.9	31,012.3
Урьдчилгаа	20,973.1	2,724.7	(18,248.4)
Бараа материал	106,516.3	112,218.6	5,702.3
Үндсэн хөрөнгө	5,954,712.2	6,033,597.1	78,884.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,085,126.2</b>	<b>6,182,512.4</b>	<b>97,386.2</b>
Өр төлбөр	8,875.3	535.2	(8,340.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,076,250.9	6,181,977.2	105,726.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,085,126.2</b>	<b>6,182,512.4</b>	<b>97,386.2</b>

Авлага дансны үлдэгдэл 33,936.3 мянган төгрөг болж 31,012.3 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн урьдчилгаа, хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаснаас 1,214.2 мянга, Ковид-19 цар тахлын улмаас жил хаагдсанаас захиалсан ном, бараа АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ

материал хугацаандаа нийлүүлэгдээгүй авлага 10,780.0 мянга, Төсвийн жил дамжин хэрэгжих олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлснийг авлагаар бүртгэсэн 16,117.5 мянга, татвар, нийгмийн даатгалын шимтгэл 3,801.1 мянган төгрөгийг илүү төлж авлагаар бүртгэсэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 18,248.4 мянган төгрөгөөр буурсан нь урьд онд урьдчилгаагаар бүртгэсэн бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгдсэнээс гадна аудитын явцад 10,780.0 мянган төгрөгийг авлага дансанд залруулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,033,597.1 мянган төгрөг болж 78,884.9 мянган төгрөгөөр өссөн нь орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд цахим номын сангийн тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах, цахим мэдээллийн сан үүсгэхтэй холбоотой тоног төхөөрөмж болон гэрийг Соёлын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/50 дугаар тушаалаар олгогдсон 350,000.0 мянган төгрөгөөс санхүүжүүлж бэлтгэсэн байна.

Мөн төсвийн урсгал зардлаас батлагдсан төсвийн хүрээнд номын фондыг нэмэгдүүлж 65,712.4 мянган төгрөгийн ном иргэн, аж ахуйн нэгжээс худалдаж авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 295, 281 дүгээр тогтоолуудаар үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй 168 нэрийн 128,768.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан, цаашид ашиглах боломжтой 62 нэрийн 290,068.3 мянган төгрөгийн анхны өртөг бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж 70,792.9 мянган төгрөгөөр шинэчлэн бүртгэсэн нь тус тус нөлөөлжээ.

2008-2032 онд хэрэгжих дулааны үр ашгийн МОН-1548 дамжуулан зээлдүүлэх урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийн өрийн үлдэгдэл 4,369.8 мянган төгрөгийг төлж барагдуулсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 535.2 мянган төгрөг болж, 8,340.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо данс 105,726.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Монгол Улсын Үндэсний номын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 681,830.7 мянган төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн байна.

Үйл ажиллагааны орлогын өсөлтөд үнэ төлбөргүй хүлээж авсан орлого 83,748.1 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 113,265.8 мянган төгрөг, нэмэлт төсвийн орлого 484,831.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Үйл ажиллагааны зардал 438,505.5 мянган төгрөгөөр өсөхөд цалин, шимтгэлийн зардал 125,4470.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 73,480.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 27,166.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 175,093.6 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Номын сангийн шинэ барилга руу нүүх бэлтгэл ажлын хүрээнд “Ашиглалтын өмнөх түр алба”-ны орон тоог нэмэгдүүлснээс цалин, шимтгэлийн зардал өмнөх оноос өссөн, 2021 онд батлагдсан 122 орон тооноос 96 орон тоотой ажилласан байна.

Үндэсний номын сангийн барилга 1954 онд ашиглалтад орсон, удаан жилийн ашиглалтын явцад хуучирч, муудсан дулаан, хэрэглээний цэвэр, бохир ус, цахилгааны аюулгүй байдлыг хангаж, хэсэгчилсэн засварыг 30,316.2 мянган төгрөгөөр хийсэн бол бусад зардлын хувьд орчин цагийн номын сан үүсэж, хөгжсөний 100 жилийн ойг орон даяар зохион байгуулах ажлын хүрээнд гарсан зардлуудтай холбоотойгоор өссөн.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд шинэ номын сангийн барилга ашиглалтад орохоор тооцоолон зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,355,558.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,355,558.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,267,049.6 мянган төгрөгөөр бууруулж 2,088,509.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслийг бууруулсан шалтгаан нь номын сангийн шинэ барилгын ашиглалтад орох хугацаа хойшилсонтой холбоотой.

Төсвийн жилийн явцад хийгдсэн тодотголоор 37,098.0 мянган төгрөг бууруулан 2,051,411.1 мянган төгрөгөөр баталсан.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд 2,051,411.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,051,411.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,695,462.3 мянган төгрөгийг зарцуулж 355,948.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,695,462.3 мянган төгрөг буюу 82.6 хувьтай байгаа нь цалин, шимтгэлийн зардлыг 314,306.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,945.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь соёл урлаг хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 341,349.8 мянган төгрөгөөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажил арга хэмжээ 172.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 16,321.7 мянган төгрөгөөр, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж арга хэмжээ 805.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	<b>71805</b>	<b>Соёл урлаг</b>	2,051,411.1	1,695,462.4	355,948.7	82.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,922,340.2	1,580,990.5	341,349.7	82.2
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	4,870.8	4,698.5	172.3	96.5
1.3	80509	Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	805.0	-	805.0	-
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	123,395.1	109,773.4	13,621.7	89.0

/мянган.төгрөг/

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Улсын Үндэсний номын сан 2021 онд нэмэлт төсвийн дансаараа нийт 745,774.5 мянган төгрөгийг хүлээн авсан нь дараах орлого байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлогоор 241,097.0 мянган төгрөг
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 467,316.1 мянган төгрөг
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 37,361.4 мянган төгрөг

Нэмэлт төсвийн дансаар хүлээж авсан орлогоос нийтдээ 624,146.0 мянган төгрөгийг дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Төвд ном судрыг дижитал хэлбэрт оруулах төслийн хүрээнд төвд ном судрыг ангилж, ялгах, цэгцэлж тавиурт байршуулах, электрон каталогт оруулах, картжуулах, судрыг цахим хэлбэрт оруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэхэд 225,085.6 мянган төгрөг
- Монгол улсад орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд орон даяар хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээ болон номын сангийн программ хангамжийг хөгжүүлэх, уламжлалт номын сангаас цахим номын санд шилжих бэлтгэл ажилд 364,157.6 мянган төгрөг
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон болон орлогоос ахмад настнуудад дэмжлэг, урамшуулал олгох, төсвийн эх үүсвэр дутагдалтай зардлыг санхүүжүүлэхэд 34,902.8 мянган төгрөг

Төсвийн жилийн эцэст нэмэлт төсвийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 121,628.5 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлснээс төсвийн жил дамжин хэрэгжих Төвд ном, судрыг дижитал хэлбэрт оруулах төслийн санхүүжилт 16,117.5 мянган төгрөгийг буцаан авахаар авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторовын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 250 дугаар тогтоолоор орчин цагийн номын сан үүсэж, хөгжсөний 100 жилийн ойг 2021 онд тэмдэглэхээр баталсаны дагуу Соёлын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн А/50 тушаал гарч, ойн арга хэмжээг зохион байгуулах эрхийг Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоод шилжүүлэн 350,000.0 мянган төгрөгийг баталсан байна.

Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн А/18 дугаар тушаалаар ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө, зарцуулах төсвийг 100,000.0 мянган төгрөгөөр улсын хэмжээнд номын сангуудыг хамарсан сургалт, ажил мэргэжлийн уралдаан, шилдэг номын сан шалгаруулах, номын сан судлал, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, олон улсын эрдэм шинжилгээний хурал, номын сангийн гүйцэтгэх үүрэг болон түүхэн ойг сурталчлах, ойн арга хэмжээний хүндэтгэлийн хурал зохион байгуулахад зарцуулахаар, 250,000.0 мянган төгрөгөөр орчин үеийн цахим номын сангийн мэдээллийн нэгдсэн сан, цахим номын сангийн сан хөмрөг бүрдүүлэх, программ хангамжийг хөгжүүлэх чиглэлээр баталж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулж, баталсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгасан.

Тайлант онд нийт 153 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг бүрэн байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Үндэсний номын сан 2021 онд 2 тендерийг цахимаар зарлаж, 42,514.7 мянган төгрөгийн цахим номыг дэвтэрчлэн харуулах программын лиценз, оффис программын лиценз, зурган файлыг текст хэлбэрт шилжүүлэх программын лиценз худалдан авах ажил, 86,625.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.26-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 99.2 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100.0
Албан шаардлага	2	11,154.5	2	11,154.5	-	-	98.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>11,154.5</b>	<b>4</b>	<b>11,154.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>99.2</b>

АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 4,445.6 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчлийг шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр хүргүүлснээс 4,130.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан ба соёлын өвийн бүртгэлд бүртгэгдсэн хосгүй үнэт дурсгал, эрдэнэсийн санд хамаарах номыг түүх, соёлын дурсгалт зүйл дансанд бүртгүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Номын бүртгэл, тооллоготой холбоотой анхаарал хандуулах дараах асуудал байна. Үүнд:

- “Түвд ном судрыг каталог болон дижитал хэлбэрт оруулах” АСIP (Азийн сонгодогуудыг цахимжуулах төсөл) олон улсын төслийн санхүүжилтээр каталогжуулсан түвд ном судрын үнэлгээг хийлгэж, бүртгэх асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах;
- 2017-2022 онд хийгдэж дуусах Өрнө дахины номын сан хөмрөгийн тооллого, нүүлгэн шилжүүлэх болон нүүхийн өмнөх бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу нийт 4 сан хөмрөгт хийгдсэн номын тооллогын үр дүнг тооцож, нягтлан бодох бүртгэлд тусгах;

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 66,145.6 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 58,414.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 4,780.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,950.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 7,730.9 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 35,752.6 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 58,414.7 мянган төгрөгийн 3 залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

- Цахим номыг дэвтэрчлэн харуулах, зурган файлыг тест хэлбэрт шилжүүлэх, оффис программын лицензийг 42,514.7 мянган төгрөгөөр худалдаж авахдаа шууд зардлаар бүртгэснийг бараа материалын дансанд орлого авч, холбогдох анхан шатны баримтыг үндэслэн зарлагаар бүртгүүлсэн.
- Номын сангийн 100 жилийн ойн баримтат киног бараа материалын дансанд 9,900.0 мянган төгрөгөөр бүртгэснийг биет бус хөрөнгөнд шилжүүлж бүртгэсэн.
- Урьдчилж гарсан зардал дансанд он дамжсан авлагын үлдэгдэл 6,000.0 мянган төгрөг бүртгэлтэй байсныг авлагын дансанд шилжүүлж бүртгэсэн.

### 4.2.3 Албан шаардлага

Бараа ажил үйлчилгээ нь бүрэн нийлүүлэгдээгүй байхад 4,780.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалт “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн кассын үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төлбөртэй ажил үйлчилгээний орлогыг ажлын 1 хоногт багтаан тушаагаагүй 17 удаагийн 1,420.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын

бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөртэй ажил, үйлчилгээний орлогыг ажлын дараа өдөрт багтаан харилцах дансанд тушааж мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах.

## **2. Цахим мэдээллийн системтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад нийт шимтгэлийн дүн, ажил олгогчийн шимтгэлийн дүнгүүд зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын нийцсэн бөгөөд зохистой байх зарчимтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын цахим систем, төрийн албаны цалингийн нэгдсэн систем, татварын цахим систем зэрэг цахим системийн мэдээллүүдийг нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлтэй тохируулах, зөрүүгүй мэдээлэх

## **3. Мөнгөн зарлагын гүйлгээг баримтжуулахтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Иргэдээс ном худалдаж авсан мөнгөн зарлагыг э-баримтаар баримтжуулаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан нэг хэвийн маягт ТМ-5 төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, Татварын ерөнхий хуулийн 28.5 заалт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Иргэд, аж ахуйн нэгжээс худалдан авалт хийхдээ төлбөрийн баримтаар баталгаажуулж зарлагын гүйлгээ хийж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>														
1	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналын бичилттэй тулгахад нийт шимтгэлийн дүн, ажил олгогчийн шимтгэлийн дүнгүүд зөрүүтэй байна.	Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг Нийгмийн даатгал, татварын цахим системд үнэн зөв мэдээлж байх, түүнд тавих хяналтыг сайжруулж ажиллах	1	1,530.9							1	1,530.9
2	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Төлбөртэй үйлчилгээний орлогыг ажлын дараа өдөрт тушааж хэвшээгүй байна	Төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах	1	1,420.0							1	1,420.0
3	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Бараа, ажил үйлчилгээ бүрэн нийлүүлэгдээгүй байхад төсвөөс мөнгө шилжүүлж, авлага үүсгэсэн	Авлага, өр төлбөр үүсгэхгүй байх	1	4,780.0					1	4,780.0		
4	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Иргэдээс ном, бараа худалдаж авсан мөнгөн зарлага э-баримтаар баримтжуулаагүй байна.	Худалдан авалтыг цахим системээс гарах э-баримтаар баталгаажуулж, зарлагын гүйлгээг хийх	1	-							1	-
5	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Цахим номыг дэвтэрчлэн харуулах, зурган файлыг тест хэлбэрт шилжүүлэх, оффис программын лиценз худалдаж авахдаа шууд зардлаар бүртгэсэн	Орлогод бүртгүүлж, зарлага болгосон	1	42,514.7	1	42,514.7						
6	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Баримтат киног бараа материалын дансанд бүртгэсэн	Биет бус хөрөнгийн дансанд залруулж бүртгэсэн	1	9,900.0	1	9,900.0						
7	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Урьдчилж гарсан зардал дансанд он дамжсан авлагын үлдэгдэл бүртгэлтэй байна	Авлага данс уруу залруулсан	1	6,000.0	1	6,000.0						
<b>ДҮН</b>					<b>7</b>	<b>66,145.6</b>	<b>3</b>	<b>58,414.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>4,780.0</b>	<b>3</b>	<b>2,950.9</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал</b>														

Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	Монгол Улсын Үндэсний номын сан	АХГ-2022/207/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 153 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийг тус тус мөрдөж ажиллах;	1	-					1	-		
<b>ДҮН</b>					1						1			
<b>НИЙТ ДҮН</b>					<b>8</b>	<b>66,145.6</b>	<b>3</b>	<b>58,414.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>4,780.0</b>	<b>3</b>	<b>2,950.9</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 258/А.0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/207/НА-СН-ТШС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант жилд нийт 4,780,000.00 төгрөгийн ном, бараа материалын үнийг нийлүүлэгчид урьдчилан шилжүүлж, авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг зохистой удирдах, өр төлбөр үүсгэхгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо, нягтлан бодогч Э.Энхзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Б.МЯДАГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 225/2015048

Улаанбаатар хот

АХГ-2022/007/МА-СТГ-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:


Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 153 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Б.МЯДАГМАА



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.